

ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛ НЬ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ҮНДЭС БОЛОХ ТУХАЙ Л.Н.ТОЛСТОЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Р.Дарьхүү - МУИС. НШУС. Философийн тэнхмийн эрхлэгч, проф

Т.Цэрэндолгор - МУИС. НШУС. Философийн тэнхмийн магистрант

Түлхүүр үг: амьдрал, хайр, итгэл, эрх чөлөө, сайн үйл

Үл хүчирхийлэл хүний амьдралын үндэс болох тухай үзэл нь хэрэглээний ёс зүйн нэг чухал үзэл мөн. Хүний амьдралын утга учрын тухай асуудал бол философийн мөнхийн асуудлын нэг юм. Амьдралын утга учрын тухай асуултын цаана юу нуугдаж байна вэ? Энэ асуудалд хариулахын тулд эхлээд хүний амьдралын үндэс нь юу болохыг судалж мэдэх хэрэгтэй. Энэ асуудлыг судалж, өвөрмөц хариултыг өгсөн хүний нэг бол Л.Толстой мөн.

Түүний үзлээр, “хүний амьдралын үндэс нь үл хүчирхийлэл юм. Тэрхүү үл хүчирхийллийн үндэс нь хайр, итгэл, эрх чөлөө, сайн үйл юм”. Энэ талаар бичсэн түүний гол зохиолууд: “Наманчлал”(1879-1881), “Миний итгэл юунд байна вэ”(1884), “Шашин гэж юу вэ? Түүний мөн чанар юунд оршино вэ? (1884), “Бидний дотор орших бурханы хаант улс” (1890-1893), “Хүчний хууль ба хайрын хууль” (1908), “Битгий ал” (1900), “Дуугүй байж чадахгүй”(1908), “Иван Ильичийн үхэл”(1886), “Крейцеровын сонат” (1887-1889), “Ням гариг”(1889-1899) эдгээр болно.

Л.Толстойн амьдрал нь их сургуулийн хоёрдугаар курсээс гарсан, наманчлалыг хүлээн зөвшөөрсөн, дараа нь түүнд суралцсан гэж үзвэл 32 жилээр хоёр тэнцүү хэсэгт хуваагддаг, үүнээс хоёр дахь хэсэг нь нэгдэхээсээ их ялгаатай. Энэ талаар “Миний итгэл юунд байна вэ” зохиолдоо: “надад урьд нь сайхан санагдаж байсан зүйл муухай болж, урьд нь муухай санагдаж байсан зүйл сайхан болсон”, “Надад бусад хүмүүст тохиолддог зүйл тохиолдсон ажил руугаа явж байтал гэнэт замдаа ажил ямар ч хэрэггүй гэж шийдээд гэр рүүгээ буцсан, баруун талд байсан зүйл зүүн талд болсон, зүүн талд байсан зүйл баруун талд болсон” (23.304) гэж тэрээр бичсэн.

Л.Толстойн амьдралын эхний он жилүүд амжилттай, аз жаргалтай байжээ. Гүн цолтой тэрээр сайн боловсрол, баялаг өв хөрөнгө өвлөн авчээ. Л.Толстой 1851-1854 онд Кавказад цэргийн алба хааж, 1854-1855 онд Севастаполийн хамгаалалтад оролцож зоригтой офицер болохоо харуулсан. Улмаар зохиолчийн ажил түүний үндсэн ажил болж Орос улсдаа хамгийн нэр хүндтэй нэгэн сэтгэгч болсон байдаг. Түүний тууж, өгүүллэгүүд ялангуяа “Дайн ба энх”, “Анна Каренина” романуудаараа тэрээр их алдар хүндийг олж авчээ. Мөн Л.Толстой жилийн турш тариачид болон газрын эздийн хоорондох маргаанд зарга шүүгчийн алба хашсан байдаг. Гэвч Л.Толстойд энэ бүхний аль нь ч сэтгэл ханамж авчирсангүй. Түүний үйл ажиллагаа бүрийг дагалдаж байсан урам хугаралтууд нь “агаараар амьсгалж, амьтны амьдралаар амьдрах”-ын тулд башкирын тал руу хоёр сар хагас зугатсан ч, арван сар хилийн чанадад аялсан ч аварч чадаагүй бөгөөд түүний дотоод бачимдал нэмэгдэх эх үндэс болжээ.

Л.Толстойн амьдралын хоёрдугаар хагас нь нэгдүгээр хагасынхаа үгүйсгэл болсон. Тэр ихэнх хүмүүс шиг утга учраа алдсан, зөвхөн өөрийнхөө л төлөө гэсэн амьдралаар амьдарч байж гэдэг дүгнэлтэд хүрсэн. Учир нь түүний үнэлж байсан сэтгэл ханамж, нэр төр, баялаг, хүүхдүүд гээд л бүх зүйлс мөнх бус. Энэ бүгд эцэс төгсгөлгүй ертөнцийн ирээдүйд юу ч биш өчүүхэн зүйл аж. “Би амьдарсаар, явсаар ангал руу хүрч ирэхэд үхлээс өөр өмнө минь юу ч байхгүйг тодорхой олж харсан” гэж Л.Толстой бичжээ. (23.12) Ийнхүү түүний үзлээр, хүний амьдралын эмгэнэлт явдал бол амьдралд итгэхгүй байх, өөрийгөө болон бусдыг үл хайрлах, чөлөөт бус байдал, хариуцлагагүй байдал юм.

Хүний амьдралын эмгэнэлт явдлыг Л.Толстойн бодлоор эртний Энэтхэгт улайрсан араатанд бариулсан бадарчны тухай дорно дахины ёгт үлгэр харуулдаг. Араатнаас аврагдсан бадарчин усгүй худаг руу үсрэн ортол худгийн ёроолд түүнийг залгих гэж амаа ангайсан лууг тэр хардаг. Дээшээ гарвал улайрсан араатанд бариулах, худгийн ёроол руу үсэрвэл луунд идүүлэхгүйн тулд худгийн ан цавд ургасан бутны мөчрөөс зуурдаг. Зуураатай байхдаа гар нь суларч хоёр талаасаа хүлээж байгаа үхлээр заавал үхнэ гэдгээ мэдэрнэ. Тэрээр бутны их биеийг тэнцүүхэн тойрч идэж байгаа хар цагаан хоёр хулганыг олж хардаг. Тэгсээр бут хугарч тэр лууны аманд унадаг. Хар, цагаан хулгана нь хүнийг зайлшгүй үхэл рүү хөтлөх өдөр, шөнө хоёр юм. Энэ бол ёгт үлгэр биш хүн бүрт ойлгомжтой, тодорхой үнэн юм.

Амьдрал утга учиргүй юм бол сая сая хүмүүс, бүх хүн төрөлхтөн, яах гэж амьдарч байсан, амьдарсаар байгаа юм бэ? тэд амьдралд, хөдөлмөрт баясч байна гэдэг нь амьдралд ямар нэгэн утга учир байна гэсэн үг юм. Амьдралын утга учрын тухай асуулт нь төгсгөлтэй төгсгөлгүй хоёрын харилцаа, өөрөөр хэлбэл, миний мөнх бус амьдрал мөнхийн усташгүй уггатай бол тэр нь юунд оршдог юм бол? Түүнд үхэлгүй зүйл нэг ч гэсэн байгаа болов уу? Иймээс амьдралын утга учиргүй байдал, зовлонгийн тухай “Энэ асуултын хариултанд төгсгөлтэйг төгсгөлтэйтэй, төгсгөлгүйг төгсгөлгүйтэй тэнцүүлэх нь хангалттай бус, тэдний бие биетэйгээ харьцах харьцааг илрүүлэх ёстой.

Итгэл хүний амьдралын нэг үнэт зүйл билээ. Л.Толстойн үзлээр, “Итгэл бол харагдахгүй зүйлд итгэх горьдох зүйл биш. Итгэл бол амьдрах хүч”. Эдгээрээс үзэхэд, түүний хувьд хүний амьдрал итгэл дээр үндэслэсэн байна. Утга учиртай амьдрал нь итгэл үнэмшилтэй амьдрал гэдэгтэй адил юм. Итгэл нь оюун ухаанд үндэслэгдэнэ. Юуны төлөө амьдарч байгаагаа мэдэхээ болих нь хүний амьдрал буруу явж байгаагийн гэрч.

Хүний оршихуйн нэг үндсэн үзэгдэл бол эрх чөлөө юм. Энэ талаар Л.Толстой хэлэхдээ: “Эрх чөлөө гэдэг бол хүний үлэмж шинж чанар, түүний ахуйн илэрхийлэл юм”. “Хэрэв хүн бүх үнэнийг мэддэггүй, эрх чөлөөний тухай ойлголтгүй байсан бол эрх чөлөөтэй байж чадахгүй байсан. Харанхуйгаас гэрэл рүү, доороос дээшээ, төөрөгдлөөс үнэн рүү хийгдэх явцад эрх чөлөө бүрддэг. Түүний үзлээр, “Эрх чөлөө бол хүч чадал юм. Тэр бурхан руу явах замыг хүнд зааж өгдөг. Харин хүн ухаантай хариуцлагатай байж, бусдыг дагалдагч бус өөрийнхөөрөө л явах хэрэгтэй”.

Бурханд хандах хүний хандлагыг Л.Толстойн хувьд хүү нь эцэгтээ хандах, ажилчин нь эзэндээ хандах хандлагатай зүйрлэсэн. Түүний үзлээр, хүү нь эцгээ шүүх ёсгүй, эцгийнхээ сургаалыг дагаж, ойлгож, ач тустай байх хэрэгтэй. Яг үүний адилаар ажилчин бол ажилчин, тэр эзнээ сонсч түүний захирамжийг биелүүлнэ. Түүний амьдрал, аз жаргал эзнээсээ хамаарна гэдгийг ойлгодог. Сайн ажилчин эзэндээ амь бие хайргүй ханддаг. Хүн бурханд ч яг ингэж хандах ёстой. Хүн өөрийнхөө төлөө бус бурхны төлөө амьдардаг. Зөвхөн ийм ойлголт л хүний бурхантай холбоотой түүний зан араншингаас урган гарч ертөнц дээр хүний бодит байдал хувийн амьдралын утга учрын ойлголттой зохицдог.

Хайр бол хүний оршихуйн суурь хэрэгцээ, үнэт зүйл, хүнийг бусадтай нэгтгэж өгдөг идэвхитэй хүч, эв нэгдэлд хүрэх нэг арга хэрэгсэл юм. Л.Толстойн үзлээр, “Хүний амьдралын мөн чанар түүнийг удирдаж байвал зохих дээд хууль бол хайрын хууль юм. Бид хайрыг дээдлэх ёстой. Учир нь жинхэнэ хайр бол амьдрал өөрөө юм. Жинхэнэ хайранд айдас үл оршино. Хайр бол сайн сайханд тэмүүлэх тэмүүлэл юм. Бид нэг нэгнээ хайрлан хамгаалж байж л сайхан амьдарна. Сайн сайхан бол хайрын үр шим мөн. Тухайлбал, эх хүн өөрийгөө золиосолж хүүхдээ хайрласанаар л амьдралын сайн сайханыг хүртдэг. Энэ бол жинхэнэ хайр юм. Хамгийн чухал нь бид бие биенийгээ үг хэлээр бус, үйл хэргээр л хайрлах хэрэгтэй. Зөвхөн хайр л хүмүүст жинхэнэ амьдралыг өгдөг. Хэн бусдыг үл хайрлана тэр мунхаг буюу”.

Хайр дурлал бол сайн сайхан байх мэдрэмж, өөрөөрөө байж, өөрийгөө болон амьдралыг тэтгэгч хүч юм. Амьдралын хуулийн үндсийг бий болгогч хайр нь ёс суртахууны хууль болдог. Физикийн ертөнцийн хувьд дэлхийн татах хүч зайлшгүй, ямарч эргэлзээгүй зүйл гэдгийн адилаар ёс суртахуунлаг ертөнцийн хувьд хайрын хууль нь зайлшгүй, эргэлзээгүй зүйл юм. Газар унагаахгүйгээр гараасаа чулууг унагаж болохгүйн нэг адил ёс суртахууны доройтолд орохгүйн тулд хайрын хуулиас ухарч болохгүй. Түүний үзлээр, хайрын хууль бол: 1. Битгий уурла, хилэгнэ. Битгий ал. 2. Эхнэрээ битгий орхи. 3. Хэнд ч, хэзээ ч, юунд ч битгий тангарагла. 4. Муу үйлийг хүчээр бүү эсэргүүц, муу үйлийг тэвч. 5. Бусад ард түмнийг өөрийн дайсан гэж битгий үз. Дайснаа ч хайрла эдгээр болно.

Мөн түүнчлэн үл хүчирхийллийн эсрэг ойлголт болох хүчирхийллийн талаар ч бас тэрээр тайлбарласан буй. “Хүч хэрэглэх нь хэзээ ч ямарч нөхцөлд ашиг тустай байж чадахгүй, чамайг зодож, гомдоож байгаа үед ч хүч хэрэглэх тусламж руу гүйж болохгүй. Сайхан сэтгэлийг сайхан сэтгэлээр хариулаад зогсохгүй, уур хилэнг ч сайхан сэтгэлээр хариулах хэрэгтэй” хэмээн Л.Толстой үзжээ. Хүчирхийлэл бол хайрын эсрэг зүйл бөгөөд уур хилэнтэй нийлж, тэр шууд хайрын эсрэг болно. Уур хилэнгээр битгий эсэргүүц гэдэг нь хүчээр битгий хий гэсэн үг. Хүн хүнээ шүүхээр заяагдаагүй. Яагаад гэвэл тэр үргэлж төгс бус. Сэтгэл санаа өөрөө хууль тогтоодог. Энэ нь хүн өөрөө өөртөө эзэн, өөрийгөө захирдаг гэсэн үг.

Түүний үзлээр, “Хайр бол сэтгэлийн мөн чанар. Үл эсэргүүцэх зам нь хүн өөрийгөө бусад хүмүүсээс хөндийрүүлэх, тэдэнд хайхрамжгүй хандана гэсэн үг биш, энэ нь өөр шиг чинь бусад хүмүүсийг хүнтэй холбох бурхан руу, сэтгэл рүү хандсан зам юм”. Үл эсэргүүцэхийн ёс суртахуун бол хүн бүр өөрийн ухаан бодлоо аврах тухай бодох ёстой гэсэн шаардлага юм. Хэн нэгнийг ялтан гэж нэрлээд, түүнийг хүчээр эрсдүүлж, бид түүнээс хүний эрхийг булаан авдаг, тэгээд түүнд чи өөрийн оюун ухааны тухай бодох нөхцөлд бус байгаа тул тэр тухайд чинь бид санаа тавих болно гэж хэлнэ. Түүгээр бид өөрийгөө ч, түүнийг ч хуурдаг. Бусдын сэтгэл санааг захирч болохгүй, захирах ч хэрэггүй. Буруу үйлдлийг хүчээр эсэргүүцэхээс татгалзсанаар хүн энэ үнэнийг мэддэг. Тэр бусдыг шүүхээс татгалзаж, эсвэл өөрийгөө түүнээс илүү гэж бодохоос татгалздаг. Бусад хүмүүсийг бус, өөрөө өөрийгөө засах хэрэгтэй. Үл эсэргүүцэх нь хүний ёс суртахууны өөрийгөө төгөлдөржүүлэх идэвхт байдал юм.

Ер нь хүч хэрэглэж байгаа хүмүүс түүнийгээ бусдаас бас өөрөөсөө нуудаг. Энэ талаар тэрээр хэлэхдээ: “Хамгийн аймшигт ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа хүмүүс түүний цаана байгаа өөрийн хариуцлагаа хардаггүй. Нэг хэсэг нь шаардаж, нөгөө нь шийдэж, гуравдахь нь баталж, дөрөвдөх нь таамаглаж, тавдахь нь илтгэж, зургаадахь нь тушаал бичиж, долоо дахь нь гүйцэтгэдэг” гэжээ. Аливаа хүчирхийлэл нь эрх чөлөөгүй, хариуцлагагүй байдлын илрэл мөн. Хариуцлагатай байдлаараа үл хүчирхийлэл нь хүчирхийллээс ялгаатай. Уур хилэн, муу зүйлтэйгээ тэмцэх явдал хүнээс өөрөөс нь шалтгаална, үл эсэргүүцэхээр шийдсэн хүнд саад болох тийм хүч байхгүй ажээ. Түүний үзлээр, “Сайн үйл буруу үйлдлийн дээр ноёлох ёстой. Үл эсэргүүцнэ гэдэг нь хууль юм. Үл эсэргүүцэх үзэл нь цэцэн сургаал үг шиг биш, харин зөрчихгүйгээр зайлшгүй биелүүлэх хууль дүрэм юм. Хайрын хуулийг зөрчихийг зөвшөөрөх нь хүчирхийллийг ёс суртахууны хувьд зөвшөөрсөн гэсэн үг. Гэвч энэ нь боломжгүй зүйл юм. Хэрвээ зөвшөөрөх юм бол хэн нэгэн ямар нэгэн тохиолдолд буруу үйлдэл гэж үзсэнээ хүчээр эсэргүүцвэл хэн дуртай нь үүнийг бас тэгж хийх болно.

Бид хэрэгтэнг цаазлах үед ахиад яагаад ч юм тэр хэрэгтэн өөрчлөгдөхгүй, гэмшихгүй, нүглээ наманчлахгүй гэдэгт зуун хувь итгэлтэй байж чадахгүй. Ингэхлээр цаазаар авах ял нь ашиггүй, хэрцгий зүйл болно. Энэ талаар Л.Толстой хэлэхдээ: “Цаазаар авах ялыг зөвтгөж болохгүй, учир нь цаазаар авах ял нь хүрээлэн байгаа хүмүүс юун түүрүүнд цаазлуулсан хүмүүсийн ойр дотныхонд нөлөөлж алагдсанаас хоёр дахин их уур хилэн, дайсныг төрүүлдэг” гэжээ.

Хүчээр хүч хэрэглэхийг хязгаарлана гэдэг нь буруу, ялангуяа энэ санаа нь үл эсэргүүцэх тухай хуулиар цуцлагдсан. Хүч хэрэглэх нь амархан, тэр байнга тохиолддог. Түүнийг зөвтгөж болохгүй. Хүн бүр хуулийн болон бурхны өмнө тэгш эрхтэй, ёс суртахууны хувьд тэгш эрхтэй гэвэл хүн хүндээ хүч хэрэглэх үндэслэл байхгүй. Өөрийгөө бүхнээс илүү гэдгээ батлах, хүмүүсийн магтаалыг хүртэх, бусдаас ялгарах эрмэлзэлд орших хүний мөн чанар нь мөн хүч хэрэглэхэд оршино.

Үл эсэргүүцэх нь Л.Толстойн үзлээр, хүмүүсийн хоорондын өшөө хонзонт, бие биедээ дайсагнасан хандлагыг нөхөрсөг хамтын ажиллагааны хандлага руу өөрчлөх нэг тодорхой арга зам юм. Хүч хэрэглэх явдалд хүн өөрөө оролцохгүй байна гэдэг нь түүний эсрэг тэмцэл болно. Муу үйлдлийг эсэргүүцэж болно, эсэргүүцэх ёстой, гэхдээ хүч хэрэглэж биш, харин хүч үл хэрэглэх аргаар эсэргүүцэж болно. Үл эсэргүүцнэ гэдгийг тэрээр итгэл, хайр, үнэний эерэг хүч юм. Түүнээс гадна тийм буруу үйлдэл болон буруу үйлдлийг хийж байгаа хүнийг болиулахыг уриалсан эсэргүүцэл, маргаан, ятгалга шиг хамтран эсэргүүцэх тийм хэлбэрүүд байгаа. Ингэснээр үл хүчирхийллийн талаархи Л.Толстойн үзэл нь дайсныг найз болгож хувиргах, амьдралын оюуны үндсийг үндсээр нь өөрчлөхөд чиглэгдсэн үзэл юм.

Дүгнэлт

Үл хүчирхийлэл хүний амьдралын үндэс болох тухай Л.Толстойн үзэл баримтлал өнөө үед ч бидэнд амьдралын утга учрыг ойлгоход ач холбогдолтой байна. Үл хүчирхийлэл нь хүмүүнлэг үзэл бөгөөд олон соёлын нөхцөлд хүмүүсийн оюун санааны нэгтгэгч үндэс юм. Хүний амьдралд хайрын хууль байдаг. Хайрын хууль нь хүний сэтгэл зүрхэнд байдаг. Өөрийгөө, мөн сэтгэл санаагаа аврахын тулд хүн муу зүйл хийхээ болих, хүчээр бүхнийг шийдэхгүй байх нь чухал юм. Бид хайр, итгэл, эрх чөлөө ба үнэнийг эрхэмлэж байж амьдралыг утга учиртай, үнэ цэнэтэй болгоно. Үл хүчирхийлэл нь хүчирхийллийн муу муухайг дарж орлож, хязгаарлах төдийгүй харин бүр үндсээр нь устгах чадвартай чухал хэрэгсэл юм. Үл хүчирхийлэл энэ талаасаа хариу хүчирхийллийг бодох юм бол илүү үр дүнтэй, сайн зүйл болой.

Ашигласан ном бүтээл

- Lev Tolstoy. The Law of Love and the Law of Violence.

-Л.Н.Толстой в воспоминаниях современников. В 2-х томах. Т.1. М.,1978.

- Асмус В. Ф. Мироззрение Толстого // Асмус В. Ф. Избранные философские труды: в 2-х т. М., 1969. Т. 1

- Гусейнов А. А. Великие моралисты.- М., Республика, 1995.

- А.А. Гусейнов. Закон насилия и закон любви (теоретический комментарий одноименному трактату Л.Н. Толстого).

- Сорокин П. А. Л.Н. Толстой как философ // Русские мыслители о Лье Толстом. - Тула: Изд. Дом «Ясная Поляна», 2002.

- Хагурова Н. А. Проблема смысла жизни и смерти в философии Л. Н. Толстого: Автореф... канд. философ, наук. - М., 1995.

- Философия ненасилия Л.Н. Толстого. Екатеринбург: Изд-во Урал. Ун-та. 2002